

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХААР УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ
ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/15-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 88012671 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Б.Давааням

Аудитор

Г.Ичинхорлоо

Аудитор

Б.Ариунтуяа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт, хамрах хүрээ, аудитын арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХААР БАТАЛСАН ТӨСВИЙГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах төсвийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна

1.2. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтийг харгалзан сумдад хуваарилсан байна

1.3. Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт ирүүлсэн төсвийг хэсгийн хорооны тоо, сонгогчийн тоо зэргийг харгалзан төлөвлөсөн байна

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, 17,960.2 МЯНГАН ТӨГРӨГИЙГ БУЦААН ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА

2.1. Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна. ,

2.2. Зардлын гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэн тайлагнасан байна.

2.3. Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
МТБ	Мэдээлэл Технологийн Баг
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/Чэ

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/62 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Давааням/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Аймаг нийслэлийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2024 оны ээлжит хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Сонгуулийн хороо болон холбогдох албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулж, үнэн зөв тайлагнаж, хяналт тавьсан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг аймаг, сумын сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газарт Орон нутгийн 2024 оны ээлжит хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс хуваарилсан зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалттай холбоотой баримт материалуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, лавлагаа авах, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”
- СЕХ-ноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны

хяналтыг хэрэгжүүлж, ахлах Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо, Б.Ариунтуяа нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 19-ны өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр 41, сумдын ИТХ-ын төлөөлөгчөөр 511 төлөөлөгчийг сонгохоор 2024 оны 10 дугаар сарын 11-ны өдөр санал хураах ажлыг зохион байгуулсан байна. Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд нийт 1,086 нэр дэвшигч оролцсон байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн XXVII/33 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 01 дүгээр захирамжаар сонгуулийн хорооны нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтныг томилж, сумдын Сонгуулийн хороог 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 10 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар зарим сумдын сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан баталсан байна.

Хөвсгөл аймагт орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар 23 хэсгийн хороонд нийт 1,823 төрийн албан хаагч ажилласан байна. Үүнд:

- Аймгийн Сонгуулийн хороонд 11 ажилтан;
- Мэдээлэл технологийн багт 7 ажилтан;
- Сумын сонгуулийн хороонд 161 ажилтан;
- Хэсгийн хороодод 1,158 ажилтан;
- Мэдээлэл технологийн 154 даамал;
- Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 131;
- Цагдаагийн байгууллагын албан хаагч 196;
- Онцгой байдлын газрын 5 албан хаагч;

Хөвсгөл аймагт орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар нийт 1,801,026.9 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс хуваарилсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

/мян.төг/

№	Байгууллагын нэр	Санхүүжилт олгосон байгууллага	Санхүүжсэн дүн	Зарцуулалт
1	Аймгийн Сонгуулийн хороо	Сонгуулийн ерөнхий хороо	1,614,584.1	1,597,523.9
2	Улсын бүртгэлийн газар	Улсын бүртгэлийн ерөнхий газар	118,748.8	118,748.8
3	Цагдаагийн газар	Цагдаагийн ерөнхий газар	67,694.0	67,694.0
НИЙТ			1,801,026.9	1,783,966.7

Сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс баталсан хөрөнгөөс аймгийн Сонгуулийн хороо нийт 17,060.2 мянган төгрөгийг хэмнэж, Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1:

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахаар баталсан төсвийг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах төсвийг журмын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1¹ дэх заалтын дагуу сонгогчийн тоо, сумын хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан улсын төсвөөс олгох Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны А/68 дугаар тушаалаар баталсан ба дараах хуваарийн дагуу санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Хүснэгт №2

/мян.төг/

№	Байгууллага	Албан бичгийн дугаар	Мөнгөн дүн
1	Сонгуулийн ерөнхий хороо	2024.08.19 №3/777	51,264.0
2	Сонгуулийн ерөнхий хороо	2024.09.05 №3/834	184,410.0
3	Сонгуулийн ерөнхий хороо	2024.09.13 №3/852	108,330.0
4	Сонгуулийн ерөнхий хороо	2024.09.20 №3/893	20,045.7
5	Сонгуулийн ерөнхий хороо	2024.09.29 №3/909	36,670.0
6	Сонгуулийн ерөнхий хороо	2024.10.05 №3/940	1,213,864.4
Нийт			1,614,584.1

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардалд Сонгуулийн ерөнхий хорооноос Хөвсгөл аймгийн сонгуулийн хороонд нийт 1,615,584.1 мянган төгрөгийг хуваарилсан байна. Санхүүжилтийн хуваарийг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2² дахь заалтын дагуу зардлын нэр төрлөөр төлөвлөж зарцуулсан байна.

1.1.2 Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг журамд заасан үзүүлэлтүүдийг харгалзан сумдад хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилан ирүүлсэн санхүүжилтийг аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3 “Аймаг нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар аргачлал, байгуулагдсан сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна” гэсэн заалтын дагуу сумын хэсгийн хорооны тоо болон түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн аргачлал, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодод дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №3

/мян.төг/

№	Сумын нэр	Мөнгөн дүн	Хувь
1	Аймгийн Сонгуулийн хороо	181,432.7	11.2
2	Сумдын сонгуулийн хороо	1,433,151.5	88.8
ДҮН		1,614,584.1	100.0

Аймгийн Сонгуулийн хорооны даргын 6 удаагийн захирамжаар сумдын сонгуулийн хороонд 1,433,151.5 мянган төгрөг,

¹ Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

² Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна.

аймгийн Сонгуулийн хороонд 181,432.7 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод баталсан санхүүжилтийг олгохдоо тухай бүр заавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

1.1.3 Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт ирүүлсэн төсвийг хэсгийн хорооны тоо, сонгогчийн тоо зэргийг харгалзан төлөвлөсөн байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт улсын төсвөөс дараах санхүүжилтийг хуваарилсан байна. Үүнд

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/136 дугаар тушаалаар 118,748.8 мянган төгрөг,
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/1326 дугаар тушаалаар сонгуулийн хамгаалалтад ажиллах алба хаагчдыг томилж, Санхүү, ар талын албаны даргын баталсан төсвийн хуваарийн дагуу 67,694.0 мянган төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Хуваарилсан төсөв Хүснэгт №4

/мян.төг/

Зардлын төрөл	Цагдаагийн газрын төсөв	Улсын бүртгэлийн хэлтсийн төсөв
Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал		5,634.80
Шуудан холбооны зардал	14,700.0	
Шатахууны зардал	3,000.0	
Техник хэрэгсэл тээвэрлэх зардал		8,000.00
Саналын хуудас төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал		2,140.00
Томилолт унааны зардал	20,090.0	21,672.00
Сургалтын бусад зардал		2,546.00
Шуурхай багийн зардал		400.00
Хоолны зардал	29,904.0	
Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ		77,220.00
Тоног төхөөрөмжийн туршилт		1,136.00
Дүн	67,694.0	118,748.8

Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газарт хуваарилсан зардлыг Хөвсгөл аймгийн сонгогчийн тоо, хэсгийн хороодын тоо, алслалтын хэмжээ зэргийг харгалзан төлөвлөж хуваарилсан байна.

БҮЛЭГ 2:

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 17,060.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.1 Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн хороо 1,614,584.1 мянган төгрөг, улсын бүртгэлийн хэлтэс 118,748.8 мянган төгрөг, Цагдаагийн газар 69,700.0 мянган төгрөг нийт 1,801,026.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан бөгөөд зардлын гүйцэтгэл 1,783,966.7 мянган төгрөг буюу 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зардлын төлөвлөгөө гүйцэтгэл Хүснэгт №5

/мян.төг/

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аймгийн Сонгуулийн хороо	181,432.7	175,665.8	5,766.9	96.8

2	Сумдын сонгуулийн хороо	1,433,151.4	1,421,858.1	11,293.3	99.2
3	Улсын бүртгэлийн хэлтэс	118,748.8	118,748.8	0.0	100.0
4	Цагдаагийн газар	67,694.0	67,694.0	0.0	100.0
ДҮН		1,801,026.9	1,783,966.7	17,060.2	99.1

Хөвсгөл аймгийн сонгуулийн тойргийн хороо болон сумдын хэсгийн хороод нь санхүүжсэн хөрөнгийг зарцуулахдаа Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.2³ заалт болон Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримталсан байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 118,748.8 мянган төгрөг, Цагдаагийн газар нь 69,700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд зардлын гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлаас Хөвсгөл аймаг, сумдын сонгуулийн хороод нийт 17,060.2 мянган төгрөгийн хэмнэлтийг гаргаж СЕХ-д төвлөрүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №6

д/д	Хэсгийн хорооны нэр	Дүн	/мян.төг/
1	Аймгийн сонгуулийн хороо	5,766.9	
2	Сумдын сонгуулийн хороо	11,293.3	
Нийт дүн		17,060.2	

Аймгийн Сонгуулийн хороо нь 11 нэр төрлийн зардлаас 5,766.9 мянган төгрөг, сумдын 11

Сонгуулийн хорооноос 11,293.3 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй байна.

Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа /бичиг хэргийн материал, унаа, сурталчилгааны зардал, маягт хэвлүүлэх зардал/ шууд худалдан авалтын аргыг сонгож гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

Аудитаар нийт зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн баримтлан ажилласан байна.

2.2 Зардлын гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэн тайлагнасан байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.1 дэх хэсэгт “Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө” гэж заасны дагуу сонгуулийн зардлын гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны А/17 дугаар “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу нэгтгэн авч, тус журмын 2 дугаар хавсралтын дагуу аймгийн сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлан гаргасан байна.

³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухай сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дах хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

Хөвсгөл аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс нийт 1,614,584.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 1,597,523.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хорооны Нэгдсэн тайлангийн зардлыг төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №8

/мян.төг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Зардлын гүйцэтгэлд эзлэх хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,680.0	1,656.0	24.0	0.1
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	19,212.0	19,158.8	53.2	1.2
3	МТБ, даамлын сургалт	30,412.0	30,187.4	224.6	1.9
4	Бичиг хэргийн зардал	19,930.0	19,926.8	3.2	1.2
5	Шуудан холбооны зардал	24,300.0	24,300.0	-	1.5
6	Унааны зардал	107,281.6	107,100.0	181.6	6.7
7	Санал авах байр бэлтгэх зардал	36,300.0	36,300.0	-	2.3
8	Сурталчилгаа	24,125.0	19,979.5	4,145.5	1.3
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,820.0	1,820.0	-	0.1
10	Саналын хуудас төхөөрөмж авах, хүргэх ачаа томилолтын зардал	61,794.0	61,228.8	565.2	3.8
11	Томилолтын зардал	19,716.0	19,613.8	102.2	1.2
12	Сүлжээний судалгаа хийх зардал	4,719.8	4,719.8	-	0.3
13	Саналын хуудас устгах зардал	2,305.9	2,305.9	-	0.1
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	13,746.7	13,746.7	-	0.9
15	Санал авах байрны түлшний зардал	14,145.0	13,995.0	150.0	0.9
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	18,060.0	18,060.0	-	1.1
17	Шуурхай багийн зардал	4,660.0	4,660.0	-	0.3
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, НДШ	1,064,261.2	1,053,021.6	11,239.6	66.0
19	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоол, НДШ	135,083.2	135,083.2	-	8.5
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх зардал	8,190.0	7,920.0	270.0	0.5
21	Болзошгүй зардал	2,841.8	2,740.6	101.2	0.2
ДҮН		1,614,584.1	1,597,523.9	17,060.2	100.0

Дээрх хүснэгтээс харахад сонгууль зохион байгуулахад гарсан зардлын нэр төрөл нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 тоот захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2⁴-т заасан зардлын нэр төрөлтэй нийцэж байна.

Нийт сонгуулийн зардлын зарцуулалтын 66 хувийг Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, НДШ-ийн зардал эзэлж байгаа бол 34.0 хувийг бусад зардал эзэлж байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлыг Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар олгож журмын дагуу зарцуулсан байна.


Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн талаар: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 900.0 мянган төгрөгийн шатахуун талоны үлдэгдлийг бэлэн мөнгөөр илэрхийлж тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6.”бүх зардал”-ыг заавал бүртгэлд тусгана гэсэн заалт болон

⁴ Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна.

Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар нь Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахаар батлагдсан зардлыг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нийт зардлын дүнд эзлэх хувийг графикаар харуулбал

График №2



Цагдаагийн газрын орон нутгийн ээлжит 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын 44.2 хувийг хоолны зардал, 29.7 хувийг томилолтын зардал, 21.7 хувийг шуудан холбооны зардал, 4.4 хувийг шатахууны зардал эзэлж байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газар нь Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг хууль, журмын дагуу зарцуулж тайлагнасан байна.

2.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооны 100170022001 тоот дансны 1 дүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны дарга Б.Одончимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурж, санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10 дахь хэсэгт заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавьж, дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Аймгийн сонгуулийн хороо нь Сумын сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ хөрөнгө зарцуулах талаар тайлбар, зөвлөмжүүдийг хүргүүлсэн.
- Аймгийн сонгуулийн хорооны гишүүдэд сумын сонгуулийн хороог хариуцуулан удирдлага арга зүйгээр хангаж ажилласан.
- Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс хуваарилсан санхүүжилтэд аймаг сумдын төрийн санд түр данс нээж, төсвийг хуваарилан, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээгээр нь зардлын эрхийг нээж хяналт тавьж ажилласан. Аймаг, сумдын сонгуулийн зардлын баримт материалыг архивын нэгж болгон үдэж цэгцэлсэн.
- Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодод төсөв зарцуулалт болон бүрдүүлэх анхан шатны баримт, урамшуулал, унаа хоолны мөнгө, томилолтын зардал тооцох зэрэгт нэгдсэн тайлбар чиглэлийг хүргүүлсэн.
- Сонгуулийн хорооны мэдээллийг ил тод байлгах үүднээс аймгийн сонгуулийн хорооноос гарсан тогтоол, зөвлөмж шийдвэрүүдийг бүх сумдын сонгуулийн хороодод хүргүүлж, аймгийн сонгуулийн хорооны facebook-д тухай бүр нь тавьж ажилласан. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай сонгуулийн хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулж, сонгуулийн үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан таниулах, холбогдох мэдээллийг цаг тухай бүр хүргэж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс олгосон төсвийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
2. Орон нутгийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахаар улсын төсвөөс хуваарилсан зардлыг хууль, журмын дагуу зарцуулж 17,060.2 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.
3. Аймаг сумдын сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайланг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын хавсралтын дагуу тайлагнаж, хөрөнгийн зарцуулалтад аймаг сумдын төрийн сангаар дамжуулан хяналтыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл хөтөлж, анхан шатны баримтыг бүрдүүлж ажилласан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001
Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2024.11.19 № 49
танай _____-ны № _____-т

□ ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН □
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн
зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй.

Санал тайлбар
ирүүлээгүй.

ДАРГА  Б.ОДОНЧИМЭГ